



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 01

Могойн гол

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус
хурлын ирц мэдээллэх тухай

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.9, 69.1 дэх заалт, хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд саналын эрх бүхий энгийн хувьцааны 462596 ширхэг буюу нийт хувьцааны 51 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож, компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.9 дэх заалтад шаардлагыг хангасан тул хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болохыг мэдэгдсүгэй.

ДАРГА
ГИШҮҮН



Г.ӨНӨРЖАРГАЛ

Р. МАШБАТ

Б.БУДСҮРЭН



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 02

Могойн гол

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын
саналын хуудас тоолсон тухай

Компанийн тухай хуулийн 77.1, 77.2 дахь хэсэг болон 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Компанийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн асуудлуудад саналын хуудсаар ирүүлсэн саналыг тоолж, санал хураалтын нэгтгэсэн дүнг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд уламжилсугай.

Могойн гол ХК-ийн 829622 ширхэг энгийн хувьцаа бүхий 942 хувьцаа эзэмшигч хуралд оролцохоос 423119 ширхэг хувьцаа бүхий 3 хувьцаа эзэмшигч оролцож:

1.Компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хангалттай гэж 423119 ширхэг санал, татгалзсан 0 санал, түдгэлзсэн 0 санал өгч компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Хангалттай гэж дүгнэв.

2.ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг 423119 ширхэг санал, татгалзсан 0 санал, түдгэлзсэн 0 санал өгч 100 хувийн саналаар батлав.

3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг кумулятив аргыг ашиглаж сонгож батлав.

ТООЛЛОГЫН КОМИСС

ДАРГА	Г.ӨНӨРЖАРГАЛ
ГИШҮҮН	Р. МАШБАТ
	Б.БУДСҮРЭН





**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 03

Могойн гол

Компанийн жилийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.7, дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 63 дугаар зүйлийн 63.5 дахь заалт хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Могойн гол" ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан түүнд хийсэн аудитын дүгнэлтийг хэлэлцэн баталсугай.
2. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг "Хангалттай" гэж үнэлсүгэй.
3. Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөөний биелэлтийг хангах, үйл ажиллагааны ашигт ажиллагааг нэмэгдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Баттогтох)-д даалгасугай.

ДАРГА



Г.ГАНДЭЛГЭР



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 04

Могойн гол

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны зардлын төсөв батлах тухай

Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны зардлыг хавсралтаар баталсугай.

2. Компанийн удирдлагын зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд даалгасугай.

ДАРГА



Г. ГАНДЭЛГЭР



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 05

Могойн гол

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд
нэр дэвшигчдийг уламжлах тухай

Компанийн тухай хуулийн 77.1, 77.2 дахь хэсэг болон 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсгийг баримтлан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцсон болон саналын хуудсаар ирүүлсэн саналыг тоолж, санал хураалтын нэгтгэсэн дүнг үндэслэн ТОГТООХ нь:

Кумулятив аргаар сонгогдсон дараах нэр дэвшигчдийг ТУЗ-ийн гишүүнд томилуулахаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд уламжилсугай.

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Кумлъятив аргаар өгсөн саналын тоо
Ердийн гишүүн		
1	Г.Гандэлгэр	634616
2	Ц.Бэхбаяр	634616
3	Ч.Хуншагай	634610
4	Ё.Батсайхан	634610
5	Ж.Батболд	132
6	Н.Батдорж	130
Хараат бус гишүүд		
1	Б.Нямдаваа	423107
2	Э.Даваачулуун	423122
3	Ч.Оюунчимэг	423107
4	Б.Дорждагва	15
5	Г. Баярсайхан	0
6	Н.Нэргүй	6
7	Б.Түмэндэлгэр	0
8	Д.Мөнхбат	0
9	Л.Амарболд	0

ДАРГА
ГИШҮҮН



Г.ӨНӨРЖАРГАЛ
Р. МАШБАТ
Б.БУДСҮРЭН



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 06

Могойн гол

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг
томилох тухай

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.7, 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 63 дугаар зүйлийн 63.1 дэх заалт, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дахь заалт, “Могойн гол”ХК-ийн дүрмийн 7 дугаар заалт болон “Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын 2026 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 05 тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Могойн гол” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив санал хураалтын дүнгээр дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд: Ердийн гишүүнээр :

Г.Гандэлгэр
Ц.Бэхбаяр
Ч.Хуншагай
Ё.Батсайхан
Ж.Батболд
Н.Батдорж

Хараат бус гишүүнээр:

Б.Нямдаваа
Э.Даваачулуун
Ч.Оюунчимэг

2. Шинээр сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс эхлэн тооцсугай.

3. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг баримтлан ёс зүйтэй, үр бүтээлтэй ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ГАНДЭЛГЭР

